MMINFO.

# МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Хүн ам 3,114.976... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.11.10. Пүрэв. №200 (4570) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

Н.УЧРАЛ: ИННОВАЦИЙН САН БАЙГУУЛЖ, ТӨРӨӨС ГАРААНЫ КОМПАНИУДЫГ ДЭМЖИХ НЬ ЗӨВ

II нүүрт

ДЭЛХИЙ

ТАНИЛЦ, АНУ-ЫН 45 ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ

VII нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## Хятадаас машин импортолъё

Б.ДАВАА

“Мода Монголоор дуусдаг” гэх социализмын үеийн доромж үг бий. Эдүгээ цаг үе өөрчлөгдөхийн хэрээр хүмүүсийн хэрэглээ ч дагаад өөрчлөгдсөн. Гэвч, яг үнэндээ дэлхийн зах зээлээс аль хэдийнэ түлхэгдэн гарсан бүхий л төрлийн бизнес харин эсрэгээр Монголд цэцэглэн хөгждөг бичигдээгүй хууль үйлчилсэн хэвээр. Тэр бүрийг дурьдана гэвэл дуусахгүй. Гагцхүү ашиглалтын хугацаа нь аль хэдийнэ дуусч, хэрэглээнээс шахагдаж хогийн цэгт хаягдсан машинуудын эцсийн цэг нь Монгол болж буйг энд дурьдахыг хүслээ.

Үргэлжлэл нь III нүүрт

УЭЭЛ БОДОЛ




# АРДЧИЛСАН НАМЫН “АЛААН” ШИРҮҮСЧ ЭХЭЛЛЭЭ

Н.ПУНЦАГБОЛД

2016 оны сонгуулийн өмнө ялна гэдэгтээ итгэлтэй байсан Ардчилсан намынхан жинхэнэ утгаараа далаараа тавиулсан. Сонгуулийн дүн гарахад, АН-ынхан цус харвах дөхсөн байх. Өнгөрсөн дөрвөн жилд тэд боломжийн ажилласан. Хийсэн, бүтээсэн. Гэхдээ ард түмэн сонгуулиар тэдэнд дүн тавьж, төрийн жолоог атгаж чадахгүй гэж дүгнэсэн. Гол нь АН-ынхны эв түнжингүй байдал, эвдрэлцэл, толхилцол ард түмэнд таалагдсангүй. Фракциудынхаа “дайн”-ыг Ардчилал гэдэг үгээр халхлах гэж оролдсон санаа нь ч бүтээгүй.

Үргэлжлэл нь III нүүрт




ЧУХАЛ ХҮН

## Б.Эрдэнэцэцэг: МОНГОЛЫН КИНО УРЛАГ ЯМАР ТӨВШИНД ХҮРСНИЙГ “ЭЭЖ” КИНО ХАРУУЛЛАА

Н.БАТЗАЯА

*УДЭТ-ын 85 жилийн энэ онд тохиож буй. Д.Нацагдоржоор овоглосон, 85 жилийн түүхтэй их театрын алтан тайзнаа олон сайхан түүхэн жүжгүүд амилсан өдрүүд өнгөрч байна. Хэдхэн хоногийн өмнө их театрын тайзнаа Төрийн соёрхолт, УГЗ Г.Бирваагийн мэндэлсний 100 жилийн ой болон театрын ойд зориулсан “Харц хатан” дуулалт жүжиг амилж, үзэгчдийн хүртээл болсон билээ. Тус жүжгийн гол дүрийг Монгол Улсын СТА, УДЭТ-ын жүжигчин Б.Эрдэнэцэцэг бүтээж, амилуулсан. Тиймээс ч энэ удаагийн “Чухал хүн” буландаа эрхэм жүжигчин бүсгүйг урьж, ярилцлаа.*

**-Улсын драмын эрдмийн театрын 85 жилийн ой энэ жил тохиож байна. Монголын нэр хүндтэй театрын түүхтэй таны ажил, амьдралын гараа яалт ч үгүй холбогдоно. Тэгэхээр 23 жилийн өмнөх дурсамжаас ярилцлагаа эхлэх үү?**

Үргэлжлэл нь IV-V нүүрт

ДЭЛХИЙ

## ТАНИЛЦ, АНУ-ЫН 45 ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ДАВААХҮҮ

АНУ-ын төрийн тэргүүнийг сонгох сонгууль энэ сарын 8-нд явагдлаа. Жил гаруй хугацааны турш тус улсын дараагийн төрийн тэргүүн хэн байх талаархи асуулт дэлхий нийтийн анхаарлын төвд байсан билээ. Харин өчигдөр тэрхүү асуултын хариу гарч, Нэгдсэн улсын 45 дахь удаагийн Ерөнхийлөгчөөр үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп тодорлоо. Бизнесийн ертөнцөд аль хэдийнэ томоохон байр суурийг эзлэх болсон тэрбээр улс төрийн туршлагагүй. Гэсэн ч, Ерөнхийлөгчийн сонгуульд илт давуугаар ялалт байгуулж, бизнесийн салбараас улс төрд “урвалаа”. Эдийн засагчид, тэтгэвэртээ гарсан генералууд, экс Ерөнхийлөгчид, хэвлэлийнхэн, бүр Бүгд найрамдах намын гишүүд өөрсдөө ч Доналд Трампыг Ерөнхийлөгч болохгүй, сонгогдож болохгүй хүн гэцгээж байв. Гэсэн ч, сонгуулийн дүн тодорхой болж эхлэх үед тэрбумтан эр аль хэдийнэ 276 төлөөлөгчийн санал авч, харин Хиллари Клинтон 218 төлөөлөгчийн саналаар бүдэрсэн юм. Сонгуулийн явцыг томоохон хэвлэлүүд шууд дамжуулсан бөгөөд Бүгд найрамдах намын нэр дэвшигч ялах нь нэгэнт тодорхой болж эхэлсний дараа Доналд Трамп ялалтаа зарласан. Тэрбээр “Сая Хиллари Клинтон залгаж, баяр хүргэлээ. Тэр маш хүчтэй өрсөлдөгч байлаа. Клинтон эдүгээг хүртэл Америкийн төлөө чадах бүхнээ хийсэн. Одоо бидэнд хуваагдсан Америк улсаа нэгтгэх мөч ирлээ. Би Америкийн бүх иргэдийн Ерөнхийлөгч байх болно гэдгээ улсын нийт иргэддээ амлаж байна. Энэ бол миний хувьд маш чухал.

Үргэлжлэл нь VII нүүрт




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2430.00 | 2444.00 | ФУНТ | 2989.00 | 3155.00 |
| ЕВРО | 2704.00 | 2831.00 | РУБЛЬ | 36.10 | 39.90 |
| ИЕН | 23.66 | 24.78 | ЮАНЬ | 357.00 | 362.90 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2432.00 | 2444.00 | ФУНТ | 2990.00 | 3114.00 |
| ЕВРО | 2676.00 | 2787.00 | РУБЛЬ | 36.90 | 40.70 |
| ИЕН | 23.23 | 24.27 | ЮАНЬ | 357.00 | 362.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

## ҮЗЭЛ БОДОЛ

# АРДЧИЛСАН НАМЫН "АЛААН" ШИРҮҮСЧ ЭХЭЛЛЭЭ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Ингээд л "цэвэр шидүүлэх"-гүй юу. Сонгуулийн дараагаас АН-ынхан дээр доргүй шинэчлэл ярьсан. Намаа шинэчлэх хэрэгтэй, шинэчлэлийг ингэж хийнэ, тэгж хийх учиртай гээд л сайхан сайхан яриад л. Тэгсэн мөртлөө Үндэсний зөвлөлдөх хорооныхоо хурлыг ч хийж чадахгүй өнөөдрийг хүрсэн. Гурван ч удаа хуралдах тов гаргасан ч ядаж цуглаж чадсангүй. Цуглаагүй шалтгаанаа зарим нэг хүмүүсийн хүсэл сонирхолтой холбон тайлбарлаж байв. Сүүлдээ орон нутгийн сонгуулийн өмнө ҮЗХ хуралдах нь буруу гэж үзээд больсон гэсэн мэдээлэл өгөөд л сураггүй болсон. Энэ хугацаанд намын даргын төлөөх "тулаан"-д оролцох "дайчид" ч нэмэгдэж байв. Харин ойрноос нам доторх "алаан" улам ширүүсч эхэллээ. АН Үндэсний зөвлөлдөх хорооны хурлаа энэ сарын 16-нд хийхээр товлоод байгаа. Энэ удаад бол арай ч хойшуулахгүй байх. Харин түүнээс өмнө янз бүрийн л асуудал өрнөж байна. Мэдээж намын даргын төлөө цөөнгүй хэдэн хүн өрсөлдөж байгаа. Одоогоор намын даргын үүргийг гүйцэтгэж буй УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга асан П.Цагаан, Боловсролын сайд асан Л.Гантөмөр, Г.Батхүү гээд олон хүний нэр хөвөрч байна. Намын даргын марафонд оролцохоо илэрхийлсэн хүмүүсээс гадна дуугүйхэн санаархагчид ч дүүрэн байгаа. ҮЗХ-ны хурлын үеэр хэн нь ч, юу ч гэж яриад, бусдыгаа шүүмжлээд гараад ирж магадгүй. Наанаа баахан шинэчлэл ярьж байгаа ч цаагуураа зөвхөн намын даргын төлөөх алалцаан яваад байна. Тэд өнгөрсөн дөрвөн жилд олонхи болж, төр барьсан. Тэгэхдээ эрх мэдлээ булаацалдаж, сайдынхаа суудлыг фракциуддаа хувааж өгөх гэж ядсаар л өнгөрөөсөн. Засгийн газраа унагаасан. Үүнээсээ болоод л өнөөдөр ихэнх нь саарал ордноос "жийгдсэн". Гэтэл одоо намын даргын суудлын төлөө лидер гэж болохоор бүх гишүүд нь тэмцэлдэж эхэллээ. Ард түмэн, ардчиллыг дэмжигчид АН-аас намын дарга хүлээгээгүй, харин шинэчлэл хүлээж байгаа. Гэтэл тэр шинэчлэл яг хийгдэх үү. Энэ байдлаараа бол үгүй л болов уу. Ядаж байхад тэд зарим хүмүүсээрээ оролдож эхэллээ. Эрх барьж байхдаа л Н.Алтанхуягийн Засгийн газрыг унагаасан. Дараа нь түүний эргэн тойрон дахь хүмүүсийг "намнаж" эхэлсэн. Одоо ч энэ байдал үргэлжилж байна. Түүний эхнэрийг гадаад руу нисэх гэж байхад нь онгоц зогсоон байж баривчилсан гэсэн мэдээлэл гарсан. Мөн эхнэрийнх нь данс руу их хэмжээний мөнгө орсон гэж ч мэдээлээд байгаа. Гэтэл өчигдөр Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшихээ зарлалаа. Зарим хүмүүс түүнийг ирэх долоо хоногт баривчлан шалгах гэж байсан учраас ийм мэдэгдэл хийлээ гэж ч бичиж л байна. Мэдээж АН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх өндөр магадлалтай хүнээр нийслэлийн Засаг дарга асан Э.Бат-Үүл яригдаж байгаа. Цаашлаад мэр сэр хүмүүсийн н э р ч дуулдаж буй. Тэгэхээр намын даргын төлөөх "алалцаан"-ы хажуугаар ирэх жил болох Ерөнхийлөгчийн сонгуулийн марафон ч өрнөж эхлэв бололтой. Эхний "дажин" дөнгөж өрнөж эхэлж байхад дараагийнх нь залгаад ороод ирлээ. Нөгөө шинэчлэл бас хаана байна. Яах вэ, зарим нэг гишүүд нь байгуулсан фракциа татан буулгаж, бусаддаа үлгэр үзүүлсэн. Гэхдээ тэр хэрээр бусад нь дагаад фракциа татан буулгаад, нэг эрх ашгийн төлөө зүтгэх үү, үгүй юу, бас л эргэлзээтэй. Цаашид энэ мэтээр намын даргын төлөө болоод Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөнө гэдгээ зарлах хэдэн ч хүн нэмэгдэж магадгүй. Ер нь бол намын даргын төлөөх өрсөлдөөний хамгийн гол хүн нь Д.Эрдэнэбат гэгдэж байгаа. "Алтан гадас", "Шонхор", "МҮДН" гэсэн фракциас Д.Эрдэнэбатыг зүтгүүлж байгаа гэсэн жиг жуг байгаа. Тэгвэл нөгөө талд МҮАН, МоАХ-ноос Г.Батхүүг зүтгүүлэх юм гэсэн. За тэр бусад нөхдүүд нь бол ерөнхийдөө жижиг өрсөлдөгчид. Л.Гантөмөр бол надад фракцийн дэмжлэг хэрэггүй гэж даналзсан. Хамгийн гол нь Д.Эрдэнэбат намын дарга болбол Ерөнхийлөгчийн сонгуульд Н.Алтанхуяг нэр дэвших боломжтой болох гаргалгаа байна. Тиймдээ ч тэрбээр өчигдөр Ерөнхийлөгчид нэр дэвшихээ зарласан байх. Учир нь Д.Эрдэнэбат орон нутгийн сонгуульд намаа авч орсон. Тэгээд ч УИХ-ын сонгуультай зүйрлэхээргүй олон суудал орон нутагт авчихаад байгаа. Энэ утгаараа тэр дарга болох магадлал өндөр байж болох юм. Ямар ч байсан даргын төлөөх өрсөлдөөн иймэрхүү маягаар л үргэлжилж байна. Дээрээс нь 2016 оны сонгуулиар УИХ-д хэдхэн суудал авсан. Дөнгөж л бүлэг байгуулах хэмжээнд. Тэгээд бүлэг байгууллаа ч эрх баригчдын шийдвэрт ямар ч нөлөөгүй. Чуулганд оролцож, жаахан юм ярих л эрхтэй хэдэн гишүүнтэй байгаа. Гэтэл эхнээсээ зарим нэг хүнээ намаас хөөх асуудал хүртэл яриад эхэллээ. Тэр нь Ж.Батзандан. Өөрөө болохоор "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийн асуудал дээр Ц.Нямдорж гишүүнтэй адилхан байр суурь баримталлаа гээд намаас хөөх гэлээ гэсэн тайлбар өгсөн. Мань хүн "Эрдэнэт"-ийн 49 хувийг шалгах ажлын хэсэгт орох хүсэлтээ өгсөн юм билээ. Түүний тайлбартай холбоотойгоор АН-аас мэдэгдэл гаргасан. Сүүлдээ Ж.Батзандан гишүүний асуудал Баянзүрх дүүрэгтэй холбогдож эхэллээ. Одоохондоо АН арай ч түүнийг намаасаа хөөчихөөгүй. Харин Баянзүрх дүүргийн АН-ын хорооноос түүнийг хөөсөн юм байх. Мань хүн Баянзүрх дүүргийн Засаг дарга асан Д.Пүрэвдаваагийн эсрэг ажиллаж, унагасан бололтой юм. Тэр шөргөлцөөн нь одоо хүртэл яваад, энэ хэмжээнд хүрчихээд байгаа юм уу даа, янз нь. Энэ асуудал цаашид ч хурцдаж, мань хүн намаасаа гарахгүй л бол яах вэ. АН-д нэг иймэрхүү алаан болоод байна даа. Шуудайд хийсэн ухрийн эвэр шиг хэдэн гишүүнээ нэг тийш нь харуулж, яриад байгаа шинэчлэлээ жинхэнэ утгаар нь хийхгүй, ердөө л намын даргын төлөө, Ерөнхийлөгчийн сонгуульд хэн өрсөлдөхөд ач холбогдол өгч "дайтаад" байвал ч...



...Тэгэхээр намын даргын төлөөх "алалцаан"-ы хажуугаар ирэх жил болох Ерөнхийлөгчийн сонгуулийн марафон ч өрнөж эхлэв бололтой. Эхний "дажин" дөнгөж өрнөж эхэлж байхад дараагийнх нь залгаад ороод ирлээ. Нөгөө шинэчлэл бас хаана байна. Яах вэ, зарим нэг гишүүд нь байгуулсан фракциа татан буулгаж, бусаддаа үлгэр үзүүлсэн...

Дугаарын 60 мөр

## ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




## Хятадаас машин импортолъё

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Өөрсдөө машин үйлдвэрлэдэггүй ч, хямдхан, шатахуун бага зарцуулдаг хөл дүүжлэх унаатай болчих гэсэн хүсэлтэй иргэдийг буруутгах аргагүй. Гэвч бидний энэ хүсэл улс орныг минь хамгийн аюултай төмрийн хогийн цэг болгон хувиргаж буй юм биш биз.

Нэгэн үе Японы Засгийн газрын санаа зовнисон асуудлын нэг нь хуучин машиныг хогийн цэгт хадгалах явдал байжээ. Өмнөговь аймгийн нийт газар нутгийг дөрөв хуваасны нэгтэй тэнцэхүйц жижиг газар нутагтай тус улсын хувьд эл асуудал нэлээд хүнд туссан нь мэдээж. Тэгвэл эдүгээ асуудал нь аяндаа шийдэгдэж, хаях газар олдохгүй шахам болсон хуучин машинуудыг сайн дураараа, бүр мөнгө төлөн худалдан авах хүсэлтэй орнууд бий болсноор японовчууд дээрх асуудлаа бага ч атугай шийдсэн хэрэг. Тэр бүү хэл, "хог" худалдан авагсдын гол төлөөлөгч нь Монгол. Манайхан хямд үнэтэй, шатахуун бага зарцуулдаг, өвөл хурдан асдаг гэдэг утгаар нь Тоёота приус машиныг илүүтэй сонирхдог. Тиймээс нийслэлийн автозамын хөдөлгөөнд оролцож буй гурван машин тутмын нэг нь приус байх бөгөөд зөвхөн өнгөрсөн жил гэхэд 20 мянган приус импортолсон байх юм. Энэ нь манай улсын нийт автомашины импортын 52.5 хувьтай тэнцэж байна. Үүгээр зогсохгүй Япон, Солонгост хэдэн жил ашиглагдсан нь огт хамааралгүй. Харин Монголд орж ирээд хэдий хугацаанд явсан нь тухайн машины шинэ, хуучныг илтгэх хэмжүүр болж байгаа нь нууц биш. Агаарын бохирдлын хэмжээгээрээ Азидаа толгой цохиж буй улсад нөгөө л хуучин машинууд нь гудамжаар хөлхөлдөж, хорт утаагаа цацсаар. Улмаар хэдэн жил яваад таг зогсох үед нь мөн л задлан зардаг тогтолцоотой. Япон, солонгосчуудын гологдол хуучин машиныг худалдан авч унах, өнөөх машин нь эвдэрвэл дахин нэг хуучин машины арай гайгүй ажиллагаатай сэлбэгийг худалдан авч тавих. Ингэсээр машины сэлбэг, хэрэгслийг авах юмгүй болтол нь ашигладаг цэг нь Монгол болон хувирч байгаа юм. Энэ байдал хэдий болтол үргэлжлэх вэ. Гэхдээ гарц бий. Бусад улс орны иргэдийн адил өөрсдийн автозамын дүрэмд тохирсон зөв талдаа жолооны хүрдтэй, шинэ, хямд машин худалдан авч ашиглах боломж бидэнд байна. Ингэхдээ урд хөршөөсөө шинэ машин импортолъё. Японоос хуучин, хаягдал машин оруулж ирж байснаас хилийн цаана орших хөршөөсөө шинэ машин авъя. Эрх баригчид ч гэсэн эдийн засгийн нягт харилцаатай тус улсын Засгийн газартай гэрээ хэлцэл байгуулж, гаалийн татвараас нь хөнгөлчих хэрэгтэй. Гаалийн татвар, тээвэрлэлтийн зардал хэмнэгдсэн цагт шинэ, хямд машиныг ашиглах боломж бүрдэх бус уу. Ер нь дэлхийн томоохон машин үйлдвэрлэгч компаниудын сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэх бүхий л компаниуд БНХАУ-д байна. Түүгээр ч зогсохгүй өнгө үзэмж сайтай, чанартай төмөр хүлгүүдийг ч тэд дотооддоо үйлдвэрлэж байна. Харин үүнийг бид боломж гэж харах хэрэгтэй болов уу. Өнөө үед машингүйгээр ажил амьдралаа зохицуулна гэдэг тун хүнд. Яах вэ, нийтийн тээвэр дэлхийн бусад хотуудынх шиг сайн хөгжсөн бол нөхцөл байдал арай өөр байхсан. Гэтэл манайд төдийлөн хөгжиж амжаагүй байна. Газар нутаг томтой, тарүү байрлалтай манайх шиг оронд өөрийн гэсэн хөл дүүжлэх унаатай болох хэрэгцээ байвч, шинэ машин худалдан авах санхүүгийн боломж байхгүй тул цаашдаа ч хуучин машин худалдан авагсдын тоо цөөрөхгүй л байх. Тиймээс хуучин машинуудыг зах зээлээс шахан гаргахын тулд өмнөд хөршөөсөө машин импортолбол ямар вэ, эрх баригчид аа.

ЧУХАЛ ХҮН



# Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ: МОНГОЛЫН КИН "Э

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

-Миний хоёр дахь гэр болсон театрын маань 85 жилийн ой хэдхэн хоногийн дараа болох гэж байна. Юуны өмнө, УДЭТ-ын хамт олон болон урлагт хайртай, драмын урлагийг шимтэн үздэг үзэгчиддээ түүхт 85 жилийн ойн баярын мэндийг хүргэе. Би 1993 онд СУИС-д элсэн орж, УГЗ Д.Маамхүү, АЖ Б.Мөнхдорж багш нарынхаа шавь болсон доо. Мөн манай найруулагчдын дунд нэр хүндтэйд тооцогддог Санчигдамба багшийн шавь болж төгсөөд ажил, амьдралынхаа гараа УДЭТ-аас эхэлж байлаа. Түүнээс хойш тасралтгүй 23 жил их театртаа ажиллаж байна. Дунд нь ямар нэгэн салбар руу ороогүй. Энэ хугацаанд 70 гаруй жүжиг, 30 орчим кинонд гол болон туслах дүр бүтээсэн байна. Үүнээс гадна хувиараа жүжиг, дэлгэцийн уран бүтээл нэлээдгүй хийсэн. Өнгөрсөн 23 жилийн хугацаанд уран бүтээлийн амжилт, олз омог арвин ажиллалаа. Тиймээс энэ их айлд миний залуу нас өнгөрсөн гэж хэлж болно. Цаашид ч ажиллаж, үзэгчид түмэндээ олон сайхан уран бүтээлээр бэлэг барина гэдгээ хэлмээр байна. Мөн би сүүлийн үед театрынхаа ажлын хажуугаар "Чононгоо" продакшнаа байгуулан ажиллаж байна. Манай продакшны анхны уран бүтээл болох "Ээж" уран сайхны кино олон улсын "Мөнгөн морь" кино наадамд амжилттай оролцоод ирлээ. Энэхүү наадам ОХУ-ын Уфа хотод болсон. Нийт 32 орны 27 кино өрсөлдөж, АЖ Д.Мэндбаяр эгч маань "Шилдэг эмэгтэй дүр"-ийн шагналыг хүртсэн. Энэ жилийн кино наадам их онцлогтой болсон юм билээ. "Мөнгөн морь" наадам анх удаа шилдэг эмэгтэй, эрэгтэй жүжигчнийг шалгаруулсан. Тэр шагналынх нь нэгийг АЖ Д.Мэндбаяр эгч маань "Ээж" киноны гол дүрээрээ хүртсэн. Энэ бол маш том амжилт. Учир нь 1956 онд "Ардын элч" киноны Ариунаагийн дүрийг бүтээсэн АЖ Цэвэлсүрэн гуай олон улсын наадмаас шагнал авч байсан. Түүнээс хойш Монгол Улсаас шагнал аваагүй. Мөн манай "Ээж" уран сайхны кино маань жүжигчин Б.Амарсайханы бүтээсэн "Итгэл" уран сайхны кинотой хамт Холливудын Лос Анжелес хотод "Азийн дэлхийн шилдэг кино наадам"-д 51 орны 30 гаруй кинотой өрсөлдлөө. Энэхүү наадамд амжилттай оролцож, шилдэг таван кинонд багтаж чадлаа.

**-УДЭТ Монголын хамгийн босго өндөртэй театр шүү дээ. Залуучууд энэ театрт ажиллахыг хүсч, мөрөөддөг. Таны үед ямар шалгаруулалтаар залуусыг авдаг байв?**

-Бидний үед ч УДЭТ-т орно гэдэг үлгэрийн далай байсан. Гэхдээ би их азтай хүн. Нэгдүгээр курс төгсдөг жилээ маш том найруулагчийн найруулсан "Тэнгэрийн сахил" кинонд тоглож, уран бүтээлийн гараагаа эхэлсэн. Ингэж явсаар дөрөвдүгээр курс төгсдөг жил 4-5 кинонд тоглочихсон байсан шүү. Тухайн үед кинонд тоглоно гэдэг маш том боломж, аз тохиол байлаа. Учир нь тухайн үеийн кинонууд дандаа хальсан дээр бичигдэж, улсын төсвөөр хийгддэг байсан юм. Анхны тоглосон "Тэнгэрийн сахил" кино маань Францад болсон олон улсын фестивальд тусгай байрт шалгарч, шагнал хүртэж байсан. Намайг сургууль төгсдөг жил "Говийн зэрэглээ" киноны Арсланд тоглодог Г.Доржсамбуу найруулагч дипломын ажлын гурван жүжгийг маань үзчихээд театрт ажиллах урилга өгсөн юм. Манай төгсөлтөөс гурван хүүхдэд урилга өгсний нэгд нь би багтсан. Гэхдээ тухайн үед найруулагч Г.Доржсамбуу "Урилга өглөө гээд хамраа битгий сөхөөрэй. Зүгээр л хамтарч ажиллаж үзье. Цаашид манай театрт ажиллах боломжтой хүүхэд байна уу, үгүй юу гэдгийг чинь харъя" гэсэн. Ингэж л их театрт ажиллах боломж надад олдож байлаа. Харин одоо манай театр жил бүр их сургууль төгссөн хүүхдүүдийг студи, ангийн сургалтдаа нэг жилийн хугацаанд бэлтгэж байна. Өөрөөр хэлбэл, тухайн хүүхэд нэг жилийн хугацаанд театрт ажиллаад шалгалт өгдөг. Шалгалтанд тэнцвэл үргэлжлүүлэн ажилладаг. Хувь хүнийхээ үүднээс бодоход бүтэн нэг жил театрт дагалдан жүжигчнээр ажиллачихаад, шалгалтанд унаад хасагдана гэхээр харамсалтай санагддаг. Би энэ асуудлыг театрын удирдлагад ч хэлж байсан. Нийгмийн ороо бусгаа цагт бүтэн жил явчихаад шалгалтанд унаж, ажилгүй хоцорно гэдэг маш харамсалтай. Энэ чинь хүний л амьдрал шүү дээ. Тийм учраас анх бүртгэхдээ л авна гэсэн хүүхдээ л элсүүлж болдоггүй юм уу гэдэг саналыг тавьж л байсан. Гэхдээ одоо шинэ үеийн залуус нэлээд олон гарч ирж байна л даа. Драмын театрын тайз гэдэг маш үнэтэй. Нэг дүр аваад, дүрээ амьдруулаад, дараагийн дүрд ажиллахдаа өмнөх дүрээсээ ялгагдахаар тоглох чадвартай болоход Драмын театрын тайз маш том сургалт болдог. Драмын театрын жүжигчид хүн судлалын том лабораторид ажилладаг гэж би боддог. Бас их азтай. Дэлхийн болон Монголынхоо зохиолуудыг задалж, шинжилдэг. Дүр дээрээ ажиллахаас эхлээд л зохиол, үзэгдэл дээр ч ажиллана. Тэр бүү хэл үг, өгүүлбэрээр нь хүртэл задалж ажилладаг. Тэгэхээр энэ бол маш том шинжлэх ухаан юм. Харамсалтай нь, сүүлийн үеийн хүүхэд, залуус жүжигчин болно гэж нэг их сайхан л мөрөөдөлтэй байх болж. Гэтэл би л гэхэд 23 жил ажиллаж, туршлага хуримтлуулж байж одоо л нэг гэхээр болж байна шүү дээ. Жүжигчин хүнээс авьяас бэлгээс гадна маш их хувийн зохион байгуулалт, хариуцлага, хөдөлмөрч занг шаарддаг. Тавьсан зорилгынхоо төлөө зүтгэж, тулгарсан бэрхшээл зовлонг даваад гарах сэтгэлийн тэнхээтэй байх хэрэгтэй. Мянган зовлон байсан ч даваад нэг бүтээлийн ард гарч чадвал уран бүтээлч болохын эхний маш том алхмыг хийлээ гэж үзэх ёстой.

**-Та хүүхэд насныхаа мөрөөдөлд хүрч чадсан уу. Ямар мэргэжилтэй болохыг мөрөөддөг байв?**

-Ер нь хүн амьдралынхаа туршид л суралцдаг. 70 настайдаа ч суралцаж байна шүү дээ. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн Хиллари Клинтон чинь 70 настай хэрнээ гал шиг асаад явж чадаж байна. Би багадаа урлагийн хүн болно гэж боддог байсан. Гэхдээ жүжигчин болох гэж их төөрөлдсөн. Хазгай муруй замаар нэлээд их явсан. Би арван жилийн сургуулиа төгсөөд Орос хэлний дээд сургуульд өрсөлдсөн ч тэнцэж чадахгүй, улаан шугамны ард жагссан. Тухай үед Багшийн дээдийн Кино драмын анги гэж байсан. Тэгэхдээ нэг жил өнжиж элсэлтээ авдаг байсан санагдаж байна. Намайг төгсдөг жил элсэлт нь таараагүй л дээ. Тэгээд л Анагаахын дундад орж, лаборант бага эмч мэргэжлээр суралцан сургуулиа улаан дипломтой төгссөн. Сургуулиа төгссөнийхөө дараа үргэжлүүлэн сурах боломж байсан ч надад эмч болох сонирхол байгаагүй. Тэгээд л шууд хөдөө очиж ажилласан. Тэнд олон ажил хийж үзсэн. Сувилагчаас эхлээд тарваган тахлын станцид ажиллаж байлаа. Би адуу, тарваганы мах идэж чаддаггүй. Тарвага, адуу гэхийг сонсоод л хамраа дардаг. Тэгсэн хэрнээ л тарваган тахлын станцид хүртэл ажиллаж, өдөрт 70-80 тарваганд шинжилгээ хийдэг байсан. Дараа нь аймгийнхаа эвлэлийн хороонд үзэл суртлын зааварлагч, хажуугаар нь аэробик, цэнгээнт бүжиг, уйгаржин бичгийн дугуйлан ажиллуулдаг байлаа. Ер нь хүүхэд байхаасаа л нийгмийн идэвхтэй байсан. Ингэж явсаар 1989 онд кино драмын ангид шалгалт авна гэдэг сураг сонсоод этюд, монолог, ёгт үлгэр, ритм, хэмнэл гэж юу байдгийг ч мэдэхгүй хүүхэд шалгалт өгөөд тэнцэж байлаа. Хүүхэд байхдаа их зүйлийг мөрөөднө өө. Их мөрөөдөмтгий. Оросын телевизээр гарч байгаа балетчинг харчихаад нэг хэсэг балетчин болохыг мөрөөдсөн. Мөрөөдөлдөө хөтлөгдөөд дотуур байрныхаа өрөөний ханан дээр балетчины зураг нааж, өлмий дээрээ явдаг болсон байсан шүү. Мөрөөдлөө бага багаар биелүүлж л байна. Кино продакшнтай болох юмсан гэж мөрөөддөг байлаа. Энэ мөрөөдөл минь ч биеллээ. Одоо хүүхэд, залуучуудын дотор нуугдаж буй авьяасыг илрүүлж, зорьсон зорилгодоо хүрэх анхны алхамд нь туслахаар сургалтын төв байгуулаад ажиллаж байна. Өөрийнхөө хэмжээнд бага багаар зорьсон зорилгодоо хүрч л байна даа.

**-Та нутагтаа хамгийн сүүлд хэзээ очив. Нутагтаа кино хийх гэж байгаа гэж сонссон?**

-Би Завхан аймгийн хүн. Монгол хүн болж төрснөөрөө монголчууд бахархдаг шүү дээ. Түүний нэгэн адилаар дэлхийг өөрийнхөө сахиусанд даатгаж явдаг Богд Очирваань хайрхны өлмий дор төрж, халхын тамгатай арван хутагт мэндэлсэн Завхан аймгийн Нөмрөгтөд төрсөндөө маш их бахархаж явдаг. Ийм л их бэлгэ дэмбэрэлтэй газар төрж, өссөн. Би "Алган дээр хайлсан цас" гэдэг кино зохиолынхоо зураг авалтыг ирэх оны нэгдүгээр сард нутагтаа хийхээр төлөвлөсөн. Одоогоор бэлтгэл ажлаа хангах шатанд явж байна. Яагаад гэвэл арван хутагт маань намайг харж, Богд Очирваань хайрхны минь сахиус ивээх байх. Мөн манай продакшныхан хоёр дахь уран бүтээлээ дэлхийн тавцанд дахин сойх зорилготой ажиллаж байна. Тиймээс монгол хүний зан чанар, нүүдэлчин амьдралын ахуй соёл, Монгол орны үзэсгэлэнт байгалийг кинондоо харуулна. Кино маань гурван дүртэй, сэтгэлзүйн драм төрлийн бүтээл. Олны хэсэг ч байхгүй. Гуравхан дүртэй учраас зохиол маш сайн бичигдсэн байх ёстой. Тиймээс зохиол дээрээ дахин дахин сууж байна. Ер Монголын кино урлаг ямар төвшинд байгааг "Ээж", "Итгэл" кино харуулаад ирлээ. Тиймээс дараагийн уран бүтээлээ дахин олон улсын кино наадамд сойно.

**-Та "Гэгээн Муза" наадмаас нэг дор хоёр муза хүртсэн анхны жүжигчин байх аа?**

-Би 2000 онд "Өргөс", "Аав аа намайг уучил" гэдэг хоёр







## ЧУХАЛ ХҮН

киног продессэрлэж, гол дүрд нь тоглож байсан. Энэ бүтээл маань телевизээр гараагүй л дээ. Мөн хажуугаар нь Оросын зохиолч Юли Шилавэгийн зохиолыг орчуулж, продюссерлэн "Манайд амьдаръя" жүжгийнхээ гол дүрд тоглосон юм. Энэ жүжиг хүн хөдөлмөрлөж чадвал яаж амжилтад хүрдгийн нэг тод жишээ л дээ. "Манайд амьдаръя" жүжигт ажиллаж байхдаа арай л мужаан хийгээгүй. Бүх л ажилд нь сэтгэлээ зориулж, өөрөө орж байсан. Ямар сайндаа АЖ Н.Сувд гуай "Чи наад аж ахуйн ажлаа орхи. Жүжгийн сургуулилтаа хий" гэж байсан юм. Мөн "Харц хатан" жүжгийн Сэржмядагийн дүрийг бүтээсэн. Энэ жүжигт нийт зургаан ари дуулдаг. Тэр бүхэнд дуулах чадварыг хөгжүүлэхэд СУИС-ийн дуулаачийн багш нар болон үндэсний дуу бүжгийн чуулгын найрал дууны багш нар их ажилласан. Тэгээд 2008 оны "Гэгээн Муза" наадмаас "Харц хатан" жүжгийн Сэржмядаг, "Манайд амьдаръя" жүжгийнхээ Машагийн дүрээр

...2008 оны "Гэгээн Муза" наадмаас "Харц хатан" жүжгийн Сэржмядаг, "Манайд амьдаръя" жүжгийнхээ Машагийн дүрээр "Драмын шилдэг эмэгтэй гол дүр"-ийн шагналыг хүртсэн. Нэг наадмаас хоёр шагнал авч ирсэн их гайхамшигтай бүтээл дээр ажилласан...



# НО УРЛАГ ЯМАР ТӨВШИНД ХҮРСНИЙГ ЭЖ" КИНО ХАРУУЛЛАА

"Драмын шилдэг эмэгтэй гол дүр"-ийн шагналыг хүртсэн. Нэг наадмаас хоёр шагнал авч ирсэн их гайхамшигтай бүтээл дээр ажилласан. Энэ бол 1993 оноос хойш Драмын театрын тайзнаасаа буулгүй ажиллаж, маш олон чадвартай ахмад үеийн жүжигчидтэйгээ хамтарч ажилласны үр дүн. Хамт олныхоо дунд өдий зэрэгтэй явж байгаадаа их баярладаг. Одоо хүртэл "Гэгээн Муза" наадмаас 12 жил болоход нэг наадмаас хоёр шагнал авсан эмэгтэй жүжигчин гараагүй болохоор өөрөөрөө бахархах сэтгэл төрдөг юм. Тэр жил их азтай байсан. Гуравдугаар сарын 27-нд "Гэгээн Муза" наадмаас хоёр муза аваад, тавдугаар сарын 18-нд Ерөнхийлөгчөөс "Алтан гадас" одонг хүртэж, энгэрээ мялаалгасан. Уран бүтээл, амжилтын олз омогтой он жилүүд байсан.

**-"Movie&Teathre" сургалтын төвийг байгуулж, нээлтийг нь хийлээ. Сургалт нь явагдаж эхэлсэн үү?**

-Энэ сарын 04-нд "Movie&Teathre" сургалтын төвийнхөө нээлтийг хийсэн. Сургалтын төв байгуулах санааг минь Буриад улсын Дорнод Сибирийн технологийн сургуулийн монгол талын захирлаар олон жил ажилласан гэр бүлийн найз минь дэмжиж, хөрөнгө оруулсан. Сургалтын төвийн маань байр хүүхэд, залуучуудын сурах орчинг бүрдүүлсэн сайхан байр боссон. "Movie&Teathre" сургалтын төв тайз дэлгэцийн жүжигчин, телевизийн хөтлөгчөөр хүүхдүүдийг бэлтгэхээс гадна арын албаны хүмүүсийг бэлтгэнэ. Өөрөөр хэлбэл, нүүр хувиргагч, зураач нарыг бэлтгэх юм. Кино, жүжигт тоглож байхад энэ төрлийн хүмүүсийн залуу боловсон хүчин цөөрсөн юм шиг санагдсан. Тиймээс энэ чухал ангийг нээсэн. Кино болон жүжгийн нүүр хувиргалтыг хийж байгаа хүмүүс ихэвчлэн make up артистууд байдаг. Нүүр хувиргалтын тусгай шарх, сорви, даарсан, хөхөрсөн, халуусан, хөлдсөн, түлэгдсэн гэх зэрэг нарийн зүйлийг хийдэг тоотой хэдхэн чадварлаг нүүр хувиргагч нар байна. Маш олон кино хийгдэж байгаа учраас тэр болгонд давхар явж чаддаггүй. Тийм учраас энэ чиглэлээр хүүхэд, залуусыг бэлтгэе гэж бодсон юм. Хичээл хараахан эхлээгүй байна. Энэ сарын 20-нд эхлэхээр төлөвлөсөн.

**-Энэ их уран бүтээл, ажлыг хийх эрч хүчийг та хаанаас авдаг вэ. Таныг бусад жүжигчидтэй харьцуулахад их дайчин, эрч хүчтэй санагддаг. Шүлэг бичнэ, кино зохиол бичиж, найруулна, хажуугаар нь Драмын театрынхаа жүжигт тоглодог. Сая л гэхэд сургалтын төв нээчихлээ шүү дээ?**

-Миний энэ чанар аав, ээжээс минь надад олгосон хүмүүжилтэй холбоотой. Жижигхэн аяга угаасан ч гүйцэд угааж дуусгах хүмүүжлийг надад олгосон. Миний аав их мундаг хүн байдаг л даа. Ардын их хурлын депутат хийж байсан, газар тариалангийн комбайнч хүн. Би хоёр муза авчихаад их гайхаж байсан л даа. Аав маань бас хоёр "Алтангадас", хоёр Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонтой байхгүй юу. Тиймээс би их бэлгэшээж явдаг. Аавынхаа зарим нэг занг би их хуулсан юм шиг санагддаг. Тэр дундаа шударга, уйгагүй, тэвчээртэй занг нь хуулсан юм болов уу. Мөн дарга, цэрэг ч байсан хүний өмнө долигнож сураагүй. Хэлэх зүйл байвал шууд л хэлчихдэг. Хэлэхгүй бол чимээгүй л яваад байна. Ер нь аавынхаа уйгагүй хөдөлмөрч, ээжийнхээ аливаад хүлээцтэй нягт нямбай занг авсан юм шиг байгаа юм. АЖ Н.Сувд эгч заримдаа "Яана аа, Эркаг харахаар бүр өмнөөс нь өрөвдөөд байх юм. Энэ жүжиг нь шатчих вий дээ. Энэ ер нь орлого, ашиг олох гэсэн бодолгүй явж байх шиг байна. Тасалбар нь борлогдож байна уу" гээд л байдаг юм. Би ч тоодоггүй, яваад л байдаг. Ер нь би их тайван хүн шүү дээ.

**-Та тоглолтоо хэзээ хийх вэ. Өмнө нь тоглолтоо хийнэ гэж байсан?**

-Би 1994 оноос хойш шүлэг бичиж эхэлсэн л дээ. Нэлээд олон киноны болон поп дууны шүлгийг бичсэн. Хамгийн сүүлд театрынхаа 80 жилийн ойн "Театрын алтан тайз минь" дууны шүлгийг бичсэн. Балхжав ах аяа хийгээд аваад ирсэн юм. Тэгээд л аяыг нь сонсч байгаад шүлэг бичсэн. Түүнээс хойш шүлэг тэрлээгүй л явна. Гэхдээ их олон жил ярьж байна даа. Хүмүүс энэ хүн улиг болсон юм аа л ярих юм гэж бодож магадгүй. Ирэх оны зургадугаар сарын эхээр өөрийнхөө тоглолтыг хийхээр төлөвлөж байна. Тоглолт гэхээр миний зохиосон дууны шүлэг, яруу найргаас уншаад өнгөрдөг номерын цуглуулга хиймээргүй санагдаад байгаа юм. Тайз, зохион байгуулалт, тоглогдох бүтээлүүд бүгд цогц байхаар онцгой хиймээр байна. Энэ жил үзүүлэх, харуулах бүтээл маань ганц, хоёроор нэмэгдээд байгаа учраас хэдэн жилдээ дурсагдах аятайхан тоглолт хийх юмсан гэж бодож байна. Одоо ном, цомгийнхоо ажилд орчихоод байна. Учир нь ном, цомгоо тасалбарынхаа бэлэг болгон өгөх гэж байгаа юм. Хүн үнэтэй тасалбар аваад тоглолт үзээд өнгөрөх биш дараа нь номыг нь уншаад, цомгийг нь сонсдог байвал сайхан. Энэ нь ч дурсгалтай.

**-Та урлагийн салбартаа өөрийн гэсэн байр суурийг хэдийнэ олж, тодорхой хэмжээний амжилтад хүрсэн шүү дээ. Залуу үеийнхэнд ч өөрийнхөө мэдлэгээс хуваалцаж байна. Цаашид юу хийхийг хүсч байна вэ?**

-Хэдийгээр миний мэргэжил жүжигчин ч гэсэн соёл түгээгч юм. Социализмын үед биднийг соёлын үрийг дэлгэрүүлэгч гэдэг байсан. Жүжигчин болоод 23 жил боллоо. Энэ хугацаанд олон зүйлийг бодож төлөвлөсөн дөө. Заримыг нь ч ажил хэрэг болгоод явж байна. Гэхдээ миний ганц мөрөөдөл байдаг. Биелэх эсэхийг нь мэдэхгүй байна. Би өөрийн гэсэн кино компанитай болох юмсан гэж хүсдэг. Холливудын "Universal pictures" гэдэг шиг зураг авалтын бүх л зүйл нь нэг дор төвлөрсөн томоохон кино компанитай болохыг хүсдэг. Элсэн цөл, далай, МЭӨ V зуун гэвэл тэр нь байж л байдаг. Тийм цогц компани байгуулна. Уг нь "Монгол кино үйлдвэр" гэж сайхан үйлдвэр байлаа. Харамсалтай нь материаллаг зүйлүүд нь бүгд хувь хүний гараар ороод дууслаа. Улс ч анхаардаггүй. Ер нь төр засгийн удирдлагууд урлаг соёл, боловсрол, эрүүл мэндийг хамгийн түрүүнд тавих ёстой. Би нэг зүйлд их харамсдаг. Юм болгонд улаг соёлынхон улсынхаа нүүрийг тахлаад аваад гарч байна. Том том төрийн концерт, гадны зочид төлөөлөгчид ирэхэд урлагийнхныг ашиглачихаад л чихрийн цаас шиг хаячихдаг. Тухайн орны хөгжлийг харвал урлагаар нь хэмж гэдэг үг ч байдаг. Саяа "Итгэл", "Ээж" уран сайхны кино хоёр тив дамжиж, олон улсын хэмжээний наадамд амжилттай оролцоод ирэхэд салбар яам, сайд нь таг чиг л байна. Уран бүтээлчид л бор зүрхээрээ хэдэн төгрөг олж, кино хийдэг. Хийсэн киногоо дэлхийн тавцанд гаргах гэж, өөрсдөө зардал мөнгөө даагаад л явдаг. Арай л Холливудын гудамжинд цаасан хайрцаг дэвсч унтахгүй л явж байх шиг байна. Гэтэл төрийн томчууд маш өрөөсгөл ханддаг шүү дээ. Улсын баяр наадам, уламжлал гэдэг утгаараа тэгж байж магадгүй. Морь, бөх хоёрт ямар их мөнгө хаяж байна вэ. Ямар их бооцоо, бай шагнал өгдөг юм. Тэгэхэд Монгол Улсад ганцхан Эрдмийн театр бий. Жил бүр их утааг арилгана гэж хэдэн тэрбум төгрөг төлөвлөдөг. Яагаад тэндээс багадаа таван тэрбум төгрөгийг эрдмийн театрыг засварлахад зориулж болдоггүй юм. Тайз нь ярагддаг, доороосоо тайз нь гарч ирдэг, гал, ус, хүрхрээ урсдаг том тайзтай болгож болно шүү дээ. Ерөнхийлөгчийн ивээл дор орчин үеийн театр байгуулж болно. Английн хатан хааны театр гэж байдаг. Тэр их олон идэж ууж байгаа мөнгөөрөө урлагт хөрөнгө оруулалт хиймээр санагддаг. Энгийн жишээ хэлэхэд л, улсын наадам болоход урлагийнхан л наадмын хөтөлбөрийг чимдэг. Наадмын нээлтийн ажил дуусаад л бид хувцсаа чирээд гудамжаар явдаг. Унаатай нэг нь унаандаа суугаад, зарим нь дайгдаад л явдаг. Унаагүй нэг нь хувцсаа чирээд халуун наранд хөлсөө гоожуулаад л театр дээр ирдэг. Гэх мэтчилэн олон зүйл байна. Наад захын энгийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй төр байгаад яах юм. Тэгэхээр энэ асуудал дээр Засгийн газар нэлээд анхаарал тавьж, хөрөнгө мөнгө хаях хэрэгтэй гэж би жүжигчин хүнийхээ хувьд бодож явдаг юм даа.



МЭДЭЭЛЭЛ



# Орхон аймгийн Засаг дарга Д.БАТЛУТ 100 ХОНОГТ

*Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут 2016 оны долдугаар сарын 20-нд ажлаа хүлээж авснаас хойш 230 гаруй захирамж, шийдвэр гаргаж удирдлага, зохион байгуулалт болон бодлогын төвшинд олон асуудлыг шийдвэрлэлээ. АИТХ-ын III хуралдаанаар “Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын Захирагчийн 2016-2020 оны “Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө”-г баталлаа. Ирэх дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих бодлого, хөтөлбөрийн гол цөм нь “Хүний хөгжил”-д чиглэгдэж байгаагаараа онцлог юм.*

## Гадаад харилцааны алба байгуулав




Аймгийн Засаг даргын Тамгын газар гадаад харилцаагаа өргөжүүлж олон улсын төсөл хөтөлбөрийг орон нутагтаа татан хэрэгжүүлж хамтран ажиллах зорилгоор “Гадаад харилцааны алба” байгууллаа. Өнөөдрийн байдлаар Орхон аймаг зургаан улсын 10 хоттой ах, дүүгийн найрамдалт харилцаатай ажиллаж байна. Засаг дарга Д.Батлут орон нутагт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хамтран ажиллах чиглэлээр БНЧУ-аас Монгол Улсад суугаа Бүрэн Эрхт Элчин Сайдын яамны Эдийн засгийн зөвлөх Ладислав Хораак, БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Эрхэмсэг ноён, доктор Суриш Бабуг хүлээн авч уулзлаа. Мөн өнгөрсөн есдүгээр сард БНСУ-ын Шихэн хотод айлчилж, найрамдалт харилцаа тогтоох, эрүүл мэнд, боловсрол, аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллах талаар санал солилцлоо.

## “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг эхлүүлж, 34 айлыг орон сууцаар хангав



Засгийн газраас хэрэгжүүлж буй “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хөдөө, орон нутгаас Орхон аймаг анх удаа эхлүүллээ. Ингэхдээ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Түрээсийн орон сууц”-аа бүрдүүлсэн нь давуу тал юм. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 34 орон сууцыг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуу гэр бүл, төрийн албан хаагч, хувийн хэвшилд ажиллаж буй иргэдэд олголоо. Орон сууц олголтыг Засгийн газраас гаргасан журмын дагуу сугалааны аргаар явуулсан юм. Түрээсийн орон сууц олгох ажил ирэх жилүүдэд ч үргэлжилнэ.

## “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” жишиг аймаг болно




Аймгийн хүн амын дунд тулгамдаж буй элэгний В, С, Д вирусын шалтгаант өвчлөлийг бууруулах зорилгоор “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” жишиг аймаг болох зорилт дэвшүүлж, нэг жилийн хугацаатай аян зарлалаа. Аяны хүрээнд аймгийн Засаг дарга, ЭМГ, БОЭТ болон Медипас эмнэлэг, МСНЭ-ийн Орхон аймаг дахь салбар зөвлөл болон “Эрдэнэтийн эрүүл иргэн” ТББ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

## БОЭТ–ийн Төрөх тасаг, дохиолол, камержуулалттай боллоо





Эмнэлгийн тусламж, чанар үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор БОЭТ-ийн Төрөх тасагт 13 камер мөн төрөх өрөөнд сувилагч дуудах дохиоллын зургаан төхөөрөмж, дутуу нярайд нэн шаардлагатай эм, тариа, нярайн эрт үеийн тусламж, үйлчилгээний тоног, төхөөрөмжийг орон нутгаас шийдлээ. Үүнд Засаг даргын нөөц сангаас 24.1 сая төгрөг зарцуулсан байна.

## 10 оюутан Засаг даргын нэрэмжит тэтгэлэг хүртэв




Гадаадын болон дотоодын их дээд сургуульд анх удаа элсэн суралцаж байгаа, ЭЕШ-аа 700-аас дээш үнэлгээтэй өгсөн, Үндэсний статистикийн хорооноос тогтоосон амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай өрхийн 10 оюутанд тэтгэлэг олгож, “Батламж” гардууллаа. Тэтгэлэгт хамрагдсан оюутнууд сард 70 мянга буюу жилд 700 мянган төгрөгийн тэтгэлэг авна. Энэ хичээлийн жилд 10 оюутан долоон сая төгрөгийн тэтгэлэг хүртлээ. Мөн магистр, докторын өдрийн ангид сурч байгаа гурван оюутанд “Урамшууллын тэтгэлэг” олгох бөгөөд жилд 1-3 хүртэлх сая төгрөгийн урамшуулал олгохоор ажиллаж байна.

## Ажлын байрыг хадгалах, хангах чиглэлээр “Санамж бичиг” байгууллаа

Аймгийн Засаг дарга Д.Батлут, ҮЭХ-ны дарга М.Батцоож, “Ажил олгогч эздийн холбоо” ТББ-ын тэргүүн н.Цэдэнсодном нар “Орон нутгийн нийгмийн түншлэл”-ийг бэхжүүлэх буюу ажлын байрыг хадгалах, цалин, орлогыг бууруулахгүй байх, хямралын үед төр, хувийн хэвшил хамтарч уян хатан бодлого баримтлах чиглэлээр “Санамж бичиг”-байгууллаа. Дээрх санамж бичиг нь орон нутгаас хэрэгжүүлэх гэж буй “Эрдэнэтчүүд бид эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөр буюу нэг өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах зорилттой уялдаж байгаа юм.

## Хагас коксжсон нүүрсийг өрхийн хэрэглээнд нэвтрүүллээ

Орхон аймгийн гэр хорооллын 14 мянган өрх жилд дунджаар 30 мянган тонн түүхий нүүрс түлдэг. Энэ нь агаарын бохирдлыг үүсгэж буй гол эх үүсвэр юм. Иймд аймгийн Засаг дарга Д.Батлут Дархан-Уул аймгийн “Нако түлш” компаниас хагас коксжсон нүүрс авахаар гэрээ, хэлэлцээ хийлээ. Үүний хүрээнд гэр хорооллын 14 багийн 16 цэгт хагас коксжсон нүүрсийг түүхий нүүрсний үнээр борлуулж байна. Тодруулбал, 25 кг-ын савлагаатай хагас кокосжсон нүүрс 3000, 40 кг-ынх нь 4500 төгрөг байна.

## Засаг даргын дэргэдэх “Эрдэмтдийн зөвлөл” байгууллаа

Засаг даргын зөвлөхөөр Монгол Улсын гавьяат уурхайчин, уул уурхайн салбарын зөвлөх инженер Д.Цагаач ажиллаж байна. Түүний санаачилгаар орон нутагт ажиллаж амьдарч буй 50 гаруй эрдэмтэн, докторуудын уулзалт Засаг даргын ивээл дор зохион байгуулагдав. Уулзалтаар эрдэмдтийн бүтээлийг орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтад нэвтрүүлэх зорилгоор Засаг даргын дэргэдэх “Эрдэмтдийн зөвлөл”-ийг есөн хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

## Энэ жил дөрвөн багт сургууль, цэцэрлэг шинээр барьж байна

Аймгийн Засаг дарга ажлаа хүлээж авсанаас хойш боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарт тулгамдаж буй зарим ажлуудтай танилцаж холбогдох яамдад уламжиллаа. Ялангуяа цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Даваат, Эрдэнэ, Дэнж багт баригдаж буй барилгын ажилтай танилцаж, ажлыг чанартай бөгөөд богино хугацаанд гүйцэтгэх, санхүүжилтыг цаг хугацаанд нь олгоход анхаарч ажилласан юм. Үүний хүрээнд Даваат багт байрлах 280 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, сургуулийн цогцолбор ирэх арванхоёрдугаар сард, Дэнж багийн 20 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга энэ сард ашиглалтад орно. 2017 онд Эрдэнэ багт 640 хүүхдийн багтаамжтай сургууль ашиглалтад орох бол Баянбулаг багт баригдаж буй 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын явц 70, Дэнж багийн 20 дугаар цэцэрлэгийн өргөтгөл 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

## 1А хорооллын барилгажилтыг үргэлжүүлнэ



Хөрөнгөгүйн улмаас саатаад байсан 1А хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад уламжилж эхний ээлжинд шаардлагатай дэд бүтцийн зардал буюу 6.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгахаар Засгийн газарт саналаа хүргүүллээ. Ингэснээр Орхон аймагт 1230 айлын орон сууц ашиглалтад орох суурь тавигдаж байгаа юм. Мөн 2013 оноос Франц улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр барьж буй Цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилга хугацаандаа амжихгүй байгаагийн гол шалтгаан нь улсын төсвийн санхүүжилт удаашрах зарим тохиолдолд төсөвлөгдсөн хөрөнгө нь төсвийн тодотголын үед хасагдсан байна. Үүнийг шийдвэрлэхэд холбогдох яам руу саналаа хүргүүлсэнээс гадна эзэмшлийг нь тодорхой болгохоор ажиллаж байна.

## Булган аймагтай гэрээ байгуулж, 15 салбарт хамтран ажиллана



Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалын хүрээнд Орхон-Булган аймаг дөрвөн жил тутам хамтран ажиллах гэрээ байгууллаа. 2016-2020 оны гэрээний хүрээнд Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, Байгаль орчин, Хөдөө аж ахуй, Гамшиг осол болон гал түймэртэй тэмцэх зэрэг 15 чиглэлээр 58 ажил хэрэгжүүлэхээр хамтран ажиллахаар боллоо. Гэрээг дөрвөн жилийн хугацаатай байгуулсан бөгөөд жил тутам гэрээний биелэлтээ дүгнэж ажиллана.

## Гэр хорооллыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбож эхэллээ

Гэр хорооллын өрхийг инженерийн шугам сүлжээнд холбосноор агаарын болон хөрсний бохирдол багасах ач холбогдолтой. Иймд Баянцагаан багийн ПДУ-ын хэсгийн айл өрхийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн Цагаанчулуут багийн 25, 26, 40, 41 дүгээр гудамжийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбож, гэр хорооллын иргэдийн амьдрах таатай нөхцөлийг хангасаар байна. Мөн “Ааварийн зардал”-аас Наран, Уртын гол, Рашаант, Эрдэнэ, Их залуу, Шанд багт хайрган хучилттай авто зам, Согоот багт үерийн усны суваг засварлалаа. Говил багт 37 айлын орон сууц болон Эрдэнэт үйлдвэрийн Цагдаагийн орчмын хэсэгт үерийн хамгаалалтын суваг барив.

**ЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах алба**

ДЭЛХИЙ




# ТАНИЛЦ, АНУ-ЫН 45 ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Өнгөрсөн хугацаанд намайг дэмжээгүй ч, яг энэ цаг мөчид намайг дэмжсэн тэдгээр цөөн тооны хүмүүст гүнээ талархаж байна. Та бүхний заавар, тусламжаар би энэ амжилтад хүрлээ. Цаашдаа бүгдээрээ хамтран ажиллаж, аугаа улсынхаа төлөө нэгдэцгээе. Намайг сонгосон иргэдээ хэзээ ч гомдоохгүй гэдлээ амлая" гэлээ. Мөн тэрбээр өөрийн эцэг эх, ах дүүс, эхнэр хүүхэд, сурталчилгааны багийнхандаа талархал илэрхийлэв. Түүнчлэн, түүний хүчтэй өрсөлдөгч Ардчилсан намын нэр дэвшигч Хиллари Клинтон ч мөн ялагдлаа хүлээн зөвшөөрчээ. Гэхдээ өөрийн биеэр мэдэгдэл хийсэнгүй. Сонгуулийн үр дүнгийн талаар Ардчилсан намын штабын дарга Жон Подеста мэдэгдэл хийсэн юм. Тэрбээр "Маш урт шөнө байлаа. Маш урт сонгуулийн аян байлаа. АНУ-ын ард түмэн сонголтоо хийлээ. Энд цугларсан, саналаа өгсөн хүмүүс бүгдээрээ сайхан амрах хэрэгтэй. АНУ даяар хүн бүр өөрсдийн сонголтоо хийлээ. Сонгуульд маш идэвхитэй оролцсон америкчуудаараа бахархаж байна. Өнгөрсөн хугацаанд бидэнтэй хамт байж, Ардчилсан нам сонгуульд ялагдал хүлээснээ хүлээн зөвшөөрч, сонгуульд эцэслэн дүн тавилаа. Харин АН-аас нэр дэвшигч Хиллари Клинтон өнөөдөр сонгогчдод хандан үг хэлэхгүй гэдгээ мэдэгдсэн байна. Идэвхитэй байсан та бүхэнд баярлалаа" гэж мэдэгдсэнээр сонгуульд ялагдал хүлээснээ хүлээн зөвшөөрлөө. Сонгуулийн дүн эсрэг талд гарч эхэлсний дараа Ардчилсан намынхан амаа барьж эхэлсэн тухай зарим хэвлэлд мэдээлсэн байв. Тэдний хувьд Хиллари Клинтоны оронд Берни Сандерсыг дэвшүүлсэн бол Доналд Трамп ялагдах байсан хэмээн харуусч буй аж.

## Доналд Трамп гэж хэн бэ

Доналд Жон Трамп 1946 оны долдугаар сарын 14-нд дөрвөн хүүхэдтэй айлд төржээ. Тэрбээр багадаа нэлээд дүрсгүй хүү байсан бөгөөд багш нарын эрлэг гэгддэг байж. Харин эцэг нь хүүгээ дэг журамд сургахын тулд 13 настайд нь Нью-Йоркийн цэргийн сургуульд сургах болжээ. Тэнд Трамп өрсөлдөөн гэдэг ямар чухал зүйл болохыг мэдэрч, хүссэндээ хүрэхийн тулд бага зэрэг догшин авиртай байх нь илүүдэхгүй гэдгийг ойлгосон гэдэг. Ирээдүйн тэрбумтны хүмүүжилд хамгийн их нөлөө үзүүлсэн хүн бол мэдээж эцэг Фред нь. Тэдний зан араншин ч хоорондоо тус төстэй байжээ. Эцэг нь Доналдыг тэвчээртэй байж, өөрийнхөө хүссэнийг хүнээр хийлгэх чадварт сургажээ. 1964 онд Доналд Фордхамийн их сургуульд орж хоёр жилийн дараа Пенсилвань мужийн Санхүү худалдааны их сургуульд шилжин суралцлаа. Тэр хугацаанд зөвхөн хичээлд анхаарлаа төвлөрүүлэлгүй эцгийнхээ ажилд туслаж, бизнест суралцахын зэрэгцээ үл хөдлөх хөрөнгийг сонирхож эхэлжээ. Түүний анхны ашигтай бизнес нь Огайо мужийн Цинцинати хотын дампуурсан компанийн 1200 айлын орон сууцны цогцолборыг худалдан авсан явдал байсан гэдэг. Эцэгтэйгээ зөвлөлдөн авсан уг цогцолборыг улсаас санхүүжүүлсний эцэст тэд ганц зоос ч гарздалгүй сэргээн засварлах ажлаа хийжээ. Ердөө зургаан саяар авсан цогцолборыг тэд 12 сая ам.доллараар эргүүлэн зарсан аж. Энэ амжилттай наймаа нь ирээдүйн барилгын магнатад тун их урам хайрласан гэдэг. Гэхдээ дээдсийн хүрээллийнхэнд танил муутай залуухан эрийн бизнес тэр бүр амжилт олж байсангүй. Харин 28 насны босго алхах үедээ анхны том боломжийг атгажээ. Тэрбээр Манхэттен дүүргийн баруун хэсэгт дампуурсан төмөр замын хэсэгхэн газар дээр бизнес төв барьж, үгээр зогсохгүй баячуудын гэгдэх "Commodore" зочид буудлыг засварлах тендерийг авч чадсанаар олонд танигдаж эхэлжээ. Төд удалгүй Нью-Йорк хотын барилгын салбарт өөрийн гэсэн байр суурьтай болжээ. Харин 1979 онд Тавдугаар авенюд 58 давхар, доороо үнэтэй дэлгүүртэй, гаднаа 80 фут өндөр усан оргилуууртай "Trump Tower" цогцолборыг барьж ашиглалтад оруулсан нь Д.Трампыг жинхэнэ барилгын магнат болгосон аж. Түүний "Trump Tower"-т Саудын Арабын хаан, кино од Софи Лорен зэрэг алдартнууд байр худалдаж авсан нь бүр ч сайхан сурталчилгаа болж, Д.Трампын барьсан байшинд амьдрах нь нэр төрийн баталгаа гэсэн ойлголтыг түгээжээ. Түүний өрсөлдөгчид нь байрныхаа үнийг бууруулж байхад Доналд Трамп үнийг улам өсгөдөг.Тэгэх тусам нь хүмүүс түүнээс л байр худалдаж авахыг зүтгэдэг байв. Учир нь баян хүмүүст мөнгө гол биш харин имиж, нэр төр гол нь гэдгийг Д.Трамп мэдрэмжээрээ ойлгодог аж.

Өнөөдөр Трамп гэдэг овог нэг ёсны брэнд болсон. Энэ нэр амжилт, эд баялгийн баталгаа тул худалдаж авахыг хүсэх хүмүүс ч бий. Казино, үл хөдлөх хөрөнгөөс гадна Доналд Трамп "Дэлхийн мисс" тэмцээний албан ёсны эзэмшигч. Энэ тэмцээнийг жил бүр дэлхийн 90 оронд 2.5 тэрбум хүн үздэг. Бараг 700 гаруй гадаад, дотоодын телевизийн суваг тэмцээнийг дамжуулах эрхийг худалдан авдаг. Хувийн амьдралын тухайд Доналд Трамп гурван ч удаа гэрлэсэн. Түүний одоогийн эхнэр нь Словени гаралтай загвар өмсөгч бүсгүй байдаг. Тэдний дундаас нэг хүү төрсөн бол анхны эхнэр Ивана Трамп нь Доналд, Иванка, Эрик гэсэн гурван хүүхэдтэй. Хоёр дахь эхнэр Марла нь Тиффани гэдэг охин төрүүлсэн байдаг. Доналд Трамп 2000 онд Ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлж байсан ч, дундаас нь гарч байжээ.

## Трамп цалин авахгүй

АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трампын гол имиж бол хөрөнгө. АНУ-ын эдийн засгийн Форбес сэтгүүлээс түүний хөрөнгийн нийт хэмжээг олон нийтэд зарласан удаатай. Тодруулж хэлбэл, түүний нийт хөрөнгийг 4.1 тэрбум ам.доллар гэж мэдэгдсэн юм. 2015 оны байдлаар тэрбээр найман тэрбумын хөрөнгөтэй байсан юм. Түүний хөрөнгийн хэмжээ ийн буурах болсныг хэвлэлүүд сонгуулийн кампаниттай холбон тайлбарлаж байсан. Гэхдээ шинжээчид зах зээл дэх үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурсантай холбож байлаа. Тэгвэл ам.долларын тэрбумтан Д.Трамп сонгуулийн сурталчилгааныхаа үеэр Ерөнхийлөгчөөр хэрэв сонгогдвол цалингаасаа татгалзана гэдгээ мэдэгдсэн удаатай. Харин сонгуульд ялсан тул АНУ-ын төсвөөс сар бүр 400 мянган ам.доллар хэмнэгдэх нь тодорхой боллоо. Үл хөдлөх хөрөнгийн магнат эр Нью Хэмпшир мужийн Рочестерт болсон уулзалтынхаа үеэр энэ талаар мэдэгджээ. Тэрбээр "Ерөнхийлөгчөөр хэрэв сонгогдвол, юун түрүүнд юу хийхээ би та нарт хэлье. Би цалин авахгүй" гэсэн байдаг.

## Ам.долларын ханш сулрав

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн явц Д.Трампын ялалтаар дуусах магадлал өндөр болсны дараа Мексикийн үндэсний мөнгөн тэмдэгт песогийн ханш унаж эхэлжээ. Д.Трампыг Охайо мужид ялсны дараа Мексикийн үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш найман хувиар унасан байна. Песогийн ханш хамгийн сүүлд 1994 онд л ингэж огцом унаж байжээ. Д.Трамп Ерөнхийлөгч болох юм бол Мексиктэй харилцах харилцаандаа хатуу байр суурь баримтлахаа өмнө нь олон удаа зарлаж байсан юм. Түүний хувьд мексикчүүдийг "хүчирхийлэгчид" хэмээн тодорхойлж, АНУ-д тэд л гэмт хэрэг үйлдэж буйг шүүмжилж байсан удаатай. Мөн Ерөнхийлөгчөөр сонгогдсон тохиолдолд Мексик АНУ-ын хилд хана босгоно хэмээж байв. Үүнээс гадна Трампын ялалтын мэдээлэл цацагдаж эхэлсний дараа Лондоны металлын бирж дээр алтны үнэ 2.8 хувиар өссөн ч, газрын тосны ханш унасан үзүүлэлттэй гарчээ. Нөгөөтэйгүүр, хамгийн сонирхолтой нь Доналд Трамд ялалтаа зарлаж байх үед зах зээл дэх ам.долларын бусад валюттай харьцах ханш унаж эхэлсэн байна. Тодруулбал, ам.долларын иен, евротой харьцах ханш огцом унажээ. Гадаад валютын зах зээлд мексик песогийн үнэ түүхэнд байгаагүй хэмжээнд хүртлээ унаж байхад, эсрэгээрээ Токио, БНХАУ-ын Шанхай, Австралийн Сидней, БНСУ-ын Сөүл, Сингапур, Тайван, Индонезын Жакарта, Филиппиний Манила, Тайландын Бангкок зэрэг хотуудын валютын зах зээлд ам.долларын ханш унаж эхэлсэн байна.

## Жорж Буш Доналд Трампыг дэмжсэнгүй

БНН-аас нэр дэвшин Ерөнхийлөгч болж байсан Жорж Буш Д.Трампыг сонгуульд нэр дэвшүүлэхийг эсэргүүцэж байсан улстөрчдийн нэг. Тиймээс түүнийг эхнэр Лоратайгаа хамт Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшсэн Х.Клинтоны төлөө саналаа өгсөн гэсэн мэдээлэл гарсан. Тэгвэл энэ мэдээллийг Ж.Бушийн хэвлэлийн төлөөлөгч үгүйсгэжээ. Түүний хэлснээр Ерөнхийлөгч асан сонгууль өгөхдөө Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчдийн нэрийг ч дугуйлалгүй хоосон орхиж, зөвхөн Сенат болон тойргийн Парламентын төлөө сонголтоо хийсэн гэнэ. Ингэхдээ өөрийнхөө БНН-ын нэр дэвшигчдийг дэмжжээ.

## АНУ–ын шинэ тэргүүн хатагтай

Дональд Трампын гэргий Мелания 1970 оны дөрөвдүгээр сарын 26-нд одоогийн Словени буюу хуучнаар Югославт төржээ. Тэрбээр 2006 онд АНУ-ын иргэн болж байсан юм.

Түүний эцэг Виктор Навс Югославын Коммунист намын гишүүн бөгөөд төрийн өмчит автомашины компанид борлуулалтын ажил хийдэг байжээ. Харин ээж нь хүүхдийн хувцасны үйлдвэрт хатгамалчаар ажилладаг байв. Мелания 16 наснаасаа загварын салбарт ажиллаж, моделийн гараагаа эхэлжээ. Харин 18 нас хүрээд Миланд ирж загварын агентлагуудтай гэрээ байгуулан ажиллаж байж. Харин 1998 онд Нью-Йоркт болсон загварын шоуны үеэр тэрбумтан Трамп, загвар өмсөгч Мелания нар анх уулзсанаар 2005 онд Флоридад албан ёсоор хуримаа хийжээ.

## В.Путин Доналд Трампад баяр хүргэв

Дэлхийн хамгийн том эдийн засагтай гүрний тэргүүнд санаанд оромгүй эрхэм сонгогдсоноор АНУ-ын зарим холбоотон орнууд түргэн авч, валютын зах зээл хөдөлгөөнд орж эхэлсэн. Тухайлбал, БНСУ-ын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл хуралдсан мэдээ байна. Мөн Д.Трампын ялалтын нөлөөгөөр Азийн хөрөнгийн зах зээл тэр дундаа Никкейн индекс ихээр савлаж байгаа тул Японы эрх баригчид, санхүүгийн бодлого тодорхойлогчид ч шуурхай хурал зарласан гэнэ. Өмнө нь Д.Трамп Япон, Солонгос зэрэг холбоотон орнууд АНУ-ын тусламж дэмжлэгийг авч, нөмөр нөөлгийг нь ашигласныхаа төлөө мөнгө төлөх ёстой гэж үздэгээ илэрхийлж байсан юм. Тэдний хувьд урьдчилан төсөөлж байгаагүй эрхэм ийн сонгогдсон нь том цохилт байсан нь мэдээж. Тэгвэл эсрэгээрээ оросууд баярлаж эхэлсэн гэнэ. Доналд Трамп Ерөнхийлөгч болбол ОХУ-тай харилцаагаа сайжруулна гэдгээ амлаж байсан бөгөөд үл хөдлөхийн тэрбумтан АНУ-ыг толгойлсноор ОХУ-ын эсрэг эдийн засгийн хориг цуцлагдах магадлалтай болж ирсэн. Тиймээс ч, В.Путин АНУ-ын шинэхэн Ерөнхийлөгч руу баярын цахилгаан илгээж, хоёр улсын харилцааг сайжруулан хөгжүүлэхийн зэрэгцээ олон улсын асуудлаар хамтран ажиллана гэдэгт найдаж буйгаа илэрхийлсэн байна. ОХУ-аас гадна Д.Трампын ялалтыг эергээр харж буй улсууд бас бий. Тухайлбал, Голланд, Бельги, Чех, Итали, Серби зэрэг удирдагчид нь хэт барууны үзэлтэй орнуудын зүгээс Дональд Трампт баяр хүргэж эхэлжээ.






## Хятадууд баярлаж байна

БНХАУ-ын зөнч сармагчин Геда энэ удаагийн сонгуульд үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан эрийг сонгогдоно гэж зөгнөсөн. Тэгвэл үнэхээр сармагчин худал хэлсэнгүй.Түүний зөгнөл биеллээ олж, Трамп ялалт байгуулав. Зөнч сармагчин Геда Хиллари Клинтоны зурагтай самбарын доор тавьсан гадилыг идэхээс татгалзаж, улмаар Трампын урд тавьсан жимсийг идэж, бүр зургийг нь үнсэн сонгуулийн үр дүнг зөгнөжээ. Сармагчин өмнө нь Европын хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд Португалийг ялна гэж зөгнөсөн байх бөгөөд түүний зөгнөл ёсоор болсон гэдэг. Тэгвэл энэ удаа ч худал байсангүй. Томоохон хэвлэл мэдээллийн агентлагуудын явуулсан урьдчилсан санал асуулгаар Хиллари Клинтон үргэлж тэргүүлсэн үзүүлэлттэй байсан ч, эцсийн дүндээ ялалт үл хөдлөх хөрөнгийн магнатад ирсэн. Улмаар дэлхий нийт бүхэлдээ шоконд орж байхад эсрэгээрээ Хятадын сошиал хэрэглэгчид баярлаж байна. Тэд "Weido"-д "Трамп Америкийн Мао Зедун болно", "Энэ бол аугаа ялалт. Хятадын иргэдийн хувьд том ялалт, Зүүний хүчнийхэн яллаа", "Америкчууд энэ тэнэгийн төлөө саналаа өгсөнд бүхэл дэлхий баярлаж байна", "Америк драм дууслаа. Солонгос руу шилжье" гэх зэргээр сэтгэгдлээ үлдээж эхэллээ. Гэхдээ Цагаан ордонд хэн ч суусан АНУ, Хятадын харилцаанд ноцтой өөрчлөлт орохгүй. Учир нь Ардчилсан нам, Бүгд найрамдах намын аль аль нь АНУ-Хятадын харилцаанд нэгдсэн хэв маягийг баримталдаг билээ.

NO STRESS

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр -6
Шөнө -19



Нөгөөдөр

Өдөр -9
Шөнө -15

## Өдрийн зурхай

**ӨВЛИЙН ЭХЭН ШАРАГЧИН ГАХАЙ САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Аргын тооллын:** *2016.11.9, Лхагва гараг*
**Наран ургах шингэх:** *07.49-17.22*
**Үс засуулбал:** *Эрч хүч ихэснэ*
**Барилдлага:** *Идэр*
**Шүтэн барилдлага:** *Хурьцахуй*



Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэх, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болох болой. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой.

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

# ÒÓÍÄÐÛÍ Õ¯¯



Б.ДАВАА

Дэлхийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “Sony World Photography Awards-2017” наадмын шалгаруулалт аль хэдийнэ эхэлж, дэлхийн өнцөг булан бүр дэх гэрэл зурагчид шилдэг бүтээлээ сойж эхэлжээ. Тиймээс өнөөдрийн буландаа 2015 оны тус наадмын “Хүмүүс” төрөлд хоёрдугаар байр эзэлсэн “Тундрын хүү” зургийг хүргэж байна. Энэ зургийг Симон Моррис Сибирийн Ямалын бүс нутагт авчээ. Цас мөсний оронд гэгддэг Тундрт цаа буга маллан аж төрдөг гэр бүлд долоо хоногийн турш урцанд хоноглон амьдрах үедээ тэрбээр -40 хэмийн хүйтэнг үл ажран гадаа тоглон наадаж буй ненц хүүгийн зургийг авчээ. Хүйтэн цаг агаарт зурагчны камер ажиллахгүй нэлээд асуудал үүсгэж байхад, харин хүү арьсан малгай, дээлээ өмсөн тоглон наадаж байжээ. Симон гурван гэрэл зургийн аппаратаа авч, цас мөсний оронг зорьжээ. Гэсэн ч, техник нь царцаны улмаас ажиллаагүй бөгөөд ганц камер нь л ажиллаж байсан гэдэг. Ненц овгийнхон цаа буга маллаж, түүнийхээ ашиг шимээр амьдардаг үндэстэн юм. Ямартай ч, түүний авсан энэхүү гэрэл зураг 2015 оны шилдэг бүтээлээр тодорч чадсан байна.

ДУУЛГАХ СОНИН

## “АМЬДАРЛОГИ” ирэх онд нээлтээ хийнэ



Жүжигчин Г.Ундармаагийн дэлгэцийн дөрөв дэх бүтээлийн нээлт ирэх оны эхээр болох юм байна. Тэрбээр өмнө нь “Single Ladies 1, 2”, “Тютю” хэмээх уран сайхны киног найруулж, үзэгч олны хүртээл болгосон билээ. Тэгвэл энэ удаад “Амьдарлоги” гэх өвөрмөц нэртэй романтик, инээдмийн уран сайхны киногоо хийж дуусгажээ. Г.Ундармаа тус киноны продюсерээр ажилласан бөгөөд Герман улсад ажиллаж, амьдарч буй жүжигчин О.Энхтуулыг урьж тоглуулсан юм. Тэрбээр өөрөө ч кинондоо их сургуулийн багшийн дүрийг бүтээсэн гэнэ шүү. Ямартай ч, “Амьдарлоги” хэмээх өвөрмөц нэртэй шинэхэн бүтээл ирэх онд дэлгэцнээ амилж, үзэгчдийн хүртээл болох юм байна.

FOOTBALL NEWS

## БЕЙЛ дөрвөн жил дараалан Уэльсийн ШИЛДЭГ ХӨЛБӨМБӨГЧ БОЛЛОО




Н.ПУНЦАГ

Испанийн алдарт “Реал Мадрид” клубын хагас хамгаалагч Гарет Бейл Уэльсийн 2016 оны шилдэг хөлбөмбөгч боллоо. Тэрбээр дөрвөн жил дараалан энэ шагналыг хүртэж байгаа юм. Тэр дундаа сүүлийн долоон жилд зургаа дахь удаагаа шилдэг хөлбөмбөгчөөр шалгарлаа. Тэрбээр шагнал гардах үедээ “Энэ бол миний хувьд нэр төрийн хэрэг. Багийнхаа залуус, ажилчид, хөгжөөн дэмжигчиддээ бүгдэд маш их баярлалаа” хэмээн хэлжээ. Тэрбээр өнгөрсөн улиралд “Реал”-ын хамтаар Аваргуудын лигт түрүүлсэн. Мөн шигшээ багийнхаа хамтаар Европын аварга шалгаруулах тэмцээний шөвгийн дөрөвт үлдсэн билээ.

